



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар A/104

Эрдэнэт

Г Улсын онцгой комиссын
шийдвэрийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.5 "в", 29.1.6 "л", 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 18, 20 дугаар тушаал, Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/29 дүгээр тушаал, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны A/24, A/58 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд сүүлийн 80 хоногт коронавируст халдварт (ковид-19)-ын тохиолдол бүртгэгдээгүй, "Ногоон түвшин"-ий шалгуур үзүүлэлтийг хангасан тул байгууллагуудын үйл ажиллагааг халдварт хамгааллын дэглэмийг чанд баримтлан хэвийн горимд шилжүүлж, Баян-Өндөр, Жаргалант сумдын хэмжээнд зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх болон РС тоглоомын үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн өглөөний 09.00 цагаас оройн 22.00 цаг хүртэл хугацаанд зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлсэнтэй холбогдуулан ажилтнууд болон үйлчлүүлэгчдэд халдварт хамгааллын дэглэмийг баримталж, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн "Түр журам батлах тухай" 18 дугаар тушаалыг мөрдөн үйл ажиллагаагаа зохион байгуулж ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Дээрх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Соёлчхүү), Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Эрүүл мэндийн газар

(Д.Сүхээ), Боловсрол соёл урлагийн газар (О.Ариунгэрэлт), Биеийн тамир, спортын газар (Д.Дэлгэрбаяр), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт үүрэг болгосугай.

4. Байнгын хяналтын цэгүүдээр “Ногоон бүс”-ийн аймгуудаас ирэх, явах иргэдийг эрүүл мэндийн асуумж (www.erenet.mn)-аар, халдвартын голомттой бүс нутгаас ирсэн иргэдийг түргэвчилсэн шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулж ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт даалгасугай.

5. Аймгийн хэмжээнд халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг нэгдүгээр, сум, багийн нутаг дэвсгэрт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын халдварт хамгааллын дэглэмд хяналт тавих хуваарийг хоёрдугаар, байнгын хяналтын цэгүүд дээр үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

6. Түргэвчилсэн болон ПГУ-ын оношлуурын нөөц бүрдүүлж, хүн амын дунд тандалтын шинжилгээг тогтмол зохион байгуулж, Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын бэлтгэл ажлыг хангаж, хүн амаа бүрэн хамруулан шуурхай зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ)-т, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо)-т тус тус даалгасугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүй дэмжлэгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын Хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.



Аймгийн Засаг даргын 2021 оны 02
дугаар сарын 26.-ны өдрийн 11/104
дугаар захирамжийн 1 хавсралт

**ӨДӨР ТУТМЫН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГ /НОГООН ТҮВШИН/-ИЙН ҮЕИЙН КОРОНАВИРУСТ
ХАЛДВАР /КОВИД-19/-ААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга зам	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	ЗГ-ын 2021 оны 45 дугаар тогтоол, УОК-ын 2021 оны 18, 20 дугаар тушаалын дагуу иргэн, төрийн болон аж ахуйн, нэгж байгууллагуудад халдварт хамгааллын дэглэмийг баримтлахыг сурталчлах	-Иргэдэд хэвлэл, мэдээлэл, телевиз, цахим сүлжээгээр сурталчлах, мэдээлэх, ил байршуулах -Төрийн байгууллага, хуулийн этгээдэд албан тоотоор хүргүүлэх, хэрэгжилтийг хангуулахаар үүрэгжүүлэх	2021.03.01-нээс эхлэн өдөр бүр	Шуурхай штаб НЭМТөв	АОК ХМБ-үүд
2	УОК-ын "Түр журам батлах тухай" 2021 оны 18 дугаар тушаалын хавсралтын дагуу "Ногоон түвшин"-д иргэн, төрийн болон аж ахуйн нэгж байгууллагууд хэвийн горимоор үйл ажиллагаа явуулахдаа баримтлах халдварт хамгааллын дэглэмд хяналт хийн, зөвлөмж өгөх	-Төрийн байгууллагуудад багуудыг хуваарилан УОК-ын "Түр журам батлах тухай" 2021 оны 18 дугаар тушаалын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллахаар үүрэгжүүлэх -Төрийн албан хаагч наарт хяналт хийх мэдээллийг өгөх	2021.03.01-нээс 2021.04.01 хүртэл	Төрийн байгууллагууд	АОК Шуурхай штаб АЗДТГ Жаргалант сумын ЗДТГ
3	Коронавирусийн халдварт хамтран сэжигтэй болон батлагдсан халдварт тохиолдолд авах хариу арга хэмжээг салбар байгууллагуутай хамтран шуурхай зохион байгуулах, ТУТТ-д тодотголыг тухай бүрт хийж ажиллах	-Эрсдэлийн үнэлгээг тухай бүр хийж, халдварт тархалтын түвшинг тогтоох -Голомт бүхий бүс нутгаас ирсэн иргэдийг 7 хоног гэрийн тусгаарлалтад ажиглах -Хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах -Тусгаарлах байраар сонгогдсон зочид буудлуудтай гэрээ байгуулж бэлтгэх	Хугацааны турш	Шуурхай штаб ЭМГ БОЭТ	АОК МХГ, ТГ ОБГ ЦГ
4	Хүн амын дунд коронавируст халдварт илрүүлэх тархвар зүйн тандалт судалгааг үргэлжлүүлэн түүврийн аргаар хийх	Тархвар зүйн тандалт судалгаанд: - Эмч, эмнэлгийн ажилтан - Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч	Өдөр бүр	ЭМГ Хариу шуурхай арга хэмжээний багууд	АОК МХГ ОБГ БСУГ

		<ul style="list-style-type: none"> - Худалдаа үйлчилгээний байгууллагын ажилтнууд - Хүүхдийн байгууллагын ажилтнууд - Суурь өвчтэй иргэд - Төрийн тусгай чиг үүргийн алба хаагч - Иргэд 		БОЭТ	ЭМБ-үүд
5	Халдварын тандалт судалгаа, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан халдварын тархалтын түвшинг тодорхойлж, санал, зөвлөмжийг хүргүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулах	<ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн тусламж үйлчилгээний тоон мэдээллийг нэгтгэх, дүгнэх - Халдварын тандалт судалгааны тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх - Томуу, томуу төст өвчний тандалтын тогтолцоогоор цуглуулсан сорьцод SARS-CoV-2 вирус илрүүлэх шинжилгээг давхар хийх 	Тухай бүр	ЭМГ БОЭТ	АОК МХГ ОБГ БСУГ
6	Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Ковид 19-ийн эсрэг дархлаажуулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх, дархлаажуулалтын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - ЕБСургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлж буйтай холбогдуулан дархлаажуулалтын цэгийн байршлыг дахин сонгож, үнэлэх, иргэд олон нийтэд мэдээлэл өгөх 	2021.02.24-2021.02.26	АОК ЭМГ ЭМБ-үүд	МХГ ОБГ ТГ
		<ul style="list-style-type: none"> - Дархлаажуулалтад хамрагдах зорилтот бүлгийн иргэдийг төлөвлөгөөний дагуу вакцинд хамруулах 	Тухайн хугацааны турш		
7	Эрүүл мэндийн байгууллагуудын хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх, шуурхай байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> - Шуурхай хариу арга хэмжээний баг, эмч эмнэлгийн мэргэжилтний чадавхыг дээшлүүлэх, цахим сургалтад тогтмол хамруулах - Хүний нөөц болон шаардлагатай санхүүгийн нөөцийг бүрдүүлэх - Тусгаарлан ажиглах байр, эмнэлгийн аюултай хог хаягдлыг цуглуулах, устгах 	Тухай бүр	Шуурхай штаб ЭМГ	АОК ЭМБ-үүд
8	ЕБСургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр журмын дагуу эхлүүлэх, нягтралыг бууруулах зохицуулалт хийж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, хяналт тавих	<ul style="list-style-type: none"> - ЕБСургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө халдвар хамгааллын дэглэмд үнэлгээ хийж, зөвлөмжээр өгөх, халдвартайг хийх 	2021.02.25-2021.02.28	МХГ ЭМГ БСУГ	Аймгийн Засаг даргын Зөвлөх халдвар судлагч
		<ul style="list-style-type: none"> - Харьяа өрхийн эрүүл мэндийн төвийн эмч болон хүүхдийн байгууллагын эмчийн үзлэгт хамруулан, ирциин тандалт хийж, ЭМГ-т мэдээлэх 	2021.03.01-нээс эхлэн өдөр бүр		
		<ul style="list-style-type: none"> - 39 цэцэрлэгийн 7900 хүүхдийг шимэгчийг илрүүлэх шинжилгээнд хамруулах 	2021.04.01-2021.04.15		
		<ul style="list-style-type: none"> - Сургууль, цэцэрлэгийн удирдлага, эмч, багш нарыг зөвлөмж, мэдээллээр тогтмол ханган халдвар хамгааллын дэглэмд хуваарийн дагуу хяналт тавих 	2021.02.24-нёөс эхлэн тухай бүр		
9	Шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрэх хөдөлгөөний ургалыг нэмэгдүүлэх, голомт бүхий бүс	<ul style="list-style-type: none"> - Ногоон бүс рүү зорчих хөдөлгөөнийг нээх, асуумж авч нэвтрүүлэх 	Хугацааны турш	Шуурхай штаб ЭМГ ОБГ	Баян-Өндөр сумын ЗДТГ

	нутгаас нэвтэрч байгаа иргэдийн холбогдох мэдээллийг авах, сэжигтэй тохиолдолд тандалт судалгаа хийх	-Ковид 19-ийн эсрэг вакцин хийлгэсэн иргэдийг дархлаажуулалтын магадалагааг үндэслэн нэвтрүүлэх -Голомт бүхий нутгаас ирсэн болон шинж тэмдэг бүхий сэжигтэй иргэнд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийж нэвтрүүлэх		МХГ ЦГ ТГ	Жаргалант сумын ЗДТГ
10	Худалдаа үйлчилгээний төв, зах зэрэг олон нийтийн газруудад эрсдэлийг бууруулах зорилгоор халдвартгүйтгэл хийх	-Хуваарийн дагуу халдвартгүйтгэл хийх, хяналт тавих	Хугацааны турш	ОБГ МХГ ЭМГ	Мал эмнэлэг Хувийн хэвшил
11	Халдварт хамгааллын дэглэмийг сахихтай холбоотой иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн санал хүсэлт, гомдлыг судлан шийдвэрлэх	-Нээлттэй утсаар санал хүсэлт авч, танилцуулах, шийдвэрлэх -Төрийн байгууллагаас хуваарийн дагуу хийсэн хяналтаар иргэн, төрийн болон аж ахуйн нэгж байгууллага халдварт хамгааллын дэглэм зөрчсөн, ноцтой зөрчил илэрвэл хяналтын улсын байцаагчид мэдээлэх, холбогдох арга хэмжээг авах	Хугацааны турш	Шуурхай штаб МХГ	АОК

ОО

Аймгийн Засаг даргын 2021 оны 26
дугаар сарын 26-ны өдрийн
дугаар захирамжийн II хавсралт

УОК-ЫН ДАРГЫН 2021 ОНЫ 18 ДУГААР ТУШААЛЫН ДАГУУ
АЙМГИЙН ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ХИЙХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВААРЬ

Д/д	Багийн нэр	Хяналт хийх төрийн байгууллагууд	Хяналт хийх чиглэл
1	Зэст	<ul style="list-style-type: none"> - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар - Хот байгуулалт, барилга захиалагчийн алба 	1. Төрийн байгууллагын хяналт хийх албан хаагчид Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 45 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын “Түр журам батлах тухай” 2021 оны 18 дугаар тушаалыг уншиж танилцаж, мэдээллээр хангагдсан байх
2	Оюут	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчин аялал жуулчлалын газар - Архивын тасаг 	2. Тус тогтоол, тушаалыг хяналт хийх хуваарыт багийн байгууллага, иргэд, хуулийн этгээдэд ухуулан таниулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, зөрчлийг арилгуулах, зөвлөмжөөр ханган ажиллах
3	Уурхайчин	<ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн хэлтэс - Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 	3. Халдвар хамгааллын дэглэм /амны хаалт зүүх, зайд барих, гар угаах.../ баримтлуулах
4	Хүрэнбулаг	<ul style="list-style-type: none"> - Татварын хэлтэс - Номын төв 	4. Шаардлага биелүүлээгүй, ноцтой зөрчил илэрвэл холбогдох хяналтын улсын байцаагч нарт мэдэгдэх
5	Бүрэнбүст	<ul style="list-style-type: none"> - Хүнс хөдөө аж ахуйн газар - Сэлэнгэ голын сав газрын захиргаа 	5. Багийн Засаг дарга нар харьяа нутаг дэвсгэр дэх байгууллага аж ахуйн нэгжийн судалгаа, холбогдох мэдээллээр тухайн хяналт хийх төрийн байгууллагыг хангах
6	Уртбулаг	<ul style="list-style-type: none"> - Аймгийн Засаг даргын тамгын газар 	6. Хяналт хийж буй төрийн байгууллагын хяналтын явцад тухайн багийн Засаг дарга нар хөндлөнгийн хяналт хийж, дэмжиж ажиллах
7	Согоот	<ul style="list-style-type: none"> - Статистикийн хэлтэс - Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ТӨҮГ 	
8	Наран	<ul style="list-style-type: none"> - Гэр бүл, хүүхэд залуучуудын газар 	
9	Малчин	<ul style="list-style-type: none"> - Баян-Өндөр сумын ЗДТГ 	
10	Их залуу	<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр халамж үйлчилгээний газар 	
11	Рашаант	<ul style="list-style-type: none"> - Стандарт хэмжил зүйн төв 	
12	Уртын гол	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын хэлтэс 	
13	Шанд	<ul style="list-style-type: none"> - Санхүү, хяналт, аудитын алба 	
14	Дэнж	<ul style="list-style-type: none"> - Боловсрол соёл урлагийн газар - Шуудан үйлчилгээний газар ТӨХК 	
15	Эрдэнэ	<ul style="list-style-type: none"> - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - Шүүхийн шинжилгээний алба 	
16	Цагаанчuluу т	<ul style="list-style-type: none"> - Биеийн тамир спортын газар - Эрдэнэт-Ус ТӨХК 	
17	Баянцагаан	<ul style="list-style-type: none"> - Ус цаг уур, орчны шинжилгээний газар - Авто тээврийн төв 	
18	Баянбулаг	<ul style="list-style-type: none"> - Мал эмнэлгийн газар - ЭБЦТС-ТӨХК 	
19	Булаг	<ul style="list-style-type: none"> - Хот тохижуулах газар - ЭДЦС-ТӨХК 	

20	Даваат	- Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, - ЭҮ-ДТС-ОНӨХК	7. Төрийн байгууллагууд хяналтыг 2021 оны 03 дугаар сарын 01-нээс 2021 оны 04 дүгээр сарын 01-нийг хүртэлх хугацаанд хийж, илтгэх хуудсыг аймгийн Шуурхай штабт хүлээлгэн өгнө.
21	Говил	- Гаалийн газар - ЗХ-ний 186-р анги	
22	Яргуйт	- Хотын захирагчийн алба - БОЭТөв	
25	Жаргалант сум	- Сумын ЗДТГ	
26	Нийтийн тээврийн үйлчилгээ	- Авто тээврийн төв	
27	Төмөр зам	- Мэргэжлийн хяналтын газар	

OO

Аймгийн Засаг даргын 2021 оны 02
дугаар сарын 26.-ны өдрийн 11/104
дугаар захирамжийн III хавсралт

**БАЙНГЫН ХЯНАЛТЫН ЦЭГҮҮД ДЭЭР ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ
БҮРЭЛДЭХҮҮНИЙ АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ**

Д/Д	Байгууллагын нэр	Алба хаагч	Гүйцэтгэх үүрэг
1	Онцгой байдлын газар	1	Удирдлага зохион байгуулалтаар хангах Хоногийн үүрэг гүйцэтгэсэн тухай мэдээг нэгтгэж илтгэх худсаар штабт танилцуулах, ээлж хулээлцэх ажлыг хариуцан зохион байгуулах
2	Цагдаагийн газар	1	Шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгслийн жолооч, зорчигчдын бичиг баримт, ачаа тээшинд үзлэг хийх Хяналтын цэгийн үйл ажиллагаанд сахилга бат, дэг журам, хэв журмыг хангуулах Зөрчил гаргасан иргэнд хариуцлага тооцох талаар штабт танилцуулах Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах
3	Эрүүл мэндийн газар	1	Халдвартын голомттой бүсээс ирсэн болон сэжигтэй тохиолдол бүхий иргэдээс шинжилгээ авах Хяналтын цэгийн байрнуудын эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавих, Сэжигтэй тохиолдол, шинжилгээний хариуг баталгаажуулах шаардлагатай тохиолдолд иргэдийг тусгаарлах байрны үйл ажиллагааг зохион байгуулах
4	Баян-Өндөр, Жаргалант сум	1	Иргэдийн цахим бүртгэлийг шалгах, иргэдэд заавар зөвлөмж өгөх, Хяналтын цэгийн ажлын байрны хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, орчны цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах Алба хаагчдын хоол, хүнс, халдварт хамгааллын хувцас хэрэгслийг хүргэх ажлыг зохион байгуулах